# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (403)

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- *Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- *Үндэсний баялагт ном хандивлах тухай*
- *Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2005 оны зургаадугаар сарын 14 №22 (403)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 742. | Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 470 |
| 743. | Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийг соёрхон батлах тухай | | 470 |
| 744. | Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай | | 470 |
| 745. | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 470 |
| 746. | Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 471 |
| 747. | Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай | | 471 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 748. | Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 30 | 471 |
| 749. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай | Дугаар 31 | 472 |


### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 750. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт (үргэлжлэл) | | 472 |
| 751. | Татлы Адемийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 98 | 487 |
| 752. | Сергей Дашинимаевич Намсараев, Степан Владимирович Кальмыков нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 99 | 487 |
| 753. | Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай | Дугаар 122 | 487 |
| 754. | Мөнхбатын Даваажаргалыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай | Дугаар 123 | 492 |
| 755. | Үндэсний баялагт ном хандивлах тухай | Дугаар 124 | 492 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4, 18 дугаар зүйлийн гарчгийн, 4.1, 5.5, 7.2, 8.6, 9.2, 18.2-ын "утга соёлын " гэснийг "соёлын биет бус" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлаас 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд "Программ хангамжийн бүтээгдэхүүн худалдан авагч аж ахуйн нэгжийн тухайн ажилд зарцуулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно." гэсэн 21 дэх хэсэг нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9.2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 9.2.18, 9.2.19 дэх заалт тус тус нэмсүгэй:

"9.2.18. дотоодын программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс худалдан авсан бараа;

9.2.19. импортоор нийлүүлж байгаа компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиуд."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлд "Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гарснаар тухайн хууль, зарлиг, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ болон тэдгээрийн холбогдох зүйл, заалтын үйлчилгээ нь Цэцийн эцсийн шийдвэр гарах хүртэл түдгэлзэнэ. Түдгэлзүүлж эхлэх хугацааг Цэц дүгнэлтдээ тусгайлан заана." гэсэн 4 дэх хэсэг нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.Цэцийн гишүүн дараах үндэслэл байвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарна:

1/ хянан хэлэлцэж байгаа асуудлыг урьд өмнө шүүхийн болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож байснаас хойш 2 жил өнгөрөөгүй бол;

/2 маргагч талууд буюу тэдгээрийн төлөөлөгчидтэй ойрын төрөл садан бол."

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДСОН ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Намбарын Энхбаярыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

### Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэгмидийн Цэнгэлийг Байгаль орчны болон Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр батлсугай.

2.Энэ тогтоолыг 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 31 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Намбарын Энхбаяр Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийн товыг 2005 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 13 цаг 00 минутад байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт**

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ

### ЗАГВАРЫН ДУГААРЫН ТОВЧОО

| № | Хувцас хэрэглэлийн нэр | Загварын дугаар |
|---|---|---|
| **Малгай – 1** | | |
| 1 | Ёслол албаны майхан малгай | 1-10 |
| 2 | Өдөр тутмын майхан малгай | 1-11 |
| 3 | Хээрийн даавуун малгай | 1-12 |
| 4 | Өвлийн цэгейк малгай | 1-04 |
| **Гадуур хувцас – 2** | | |
| 5 | Ёслол, албаны китель, өмд, юбка эрэгтэй, эмэгтэй | 2-38<br>2-39<br>2-40<br>2-41 |
| 6 | Өдөр тутмын хүрэм, өмд эрэгтэй, эмэгтэй | 2-42<br>2-39<br>2-43<br>2-44 |
| 7 | Хээрийн хүрэм, өмд эрэгтэй, эмэгтэй | 2-45<br>2-46<br>2-47<br>2-48 |
| 8 | Цэгейк захтай, юүдэнтэй хүрэм, өмд эрэгтэй, эмэгтэй | 2-49<br>2-50<br>2-51<br>2-52 |
| 9 | Цув эрэгтэй, эмэгтэй | 2-53<br>2-54 |
| 10 | Ноосон ороолт | 2-55 |
| 11 | Савхин бээлий (хар өнгөтэй) эрэгтэй, эмэгтэй | 2-32<br>2-33 |
| 12 | Даавуун бээлий (цагаан өнгөтэй) эрэгтэй, эмэгтэй | 2-36<br>2-37 |
| **Дотуур хувцас – 3** | | |
| 13 | Урт ханцуйтай цамц (цагаан өнгөтэй) эрэгтэй, эмэгтэй | 3-19<br>3-20 |
| 14 | Богино ханцуйтай цамц (цагаан өнгөтэй) эрэгтэй, эмэгтэй | 3-21<br>3-22 |
| 15 | Зангиа (хар өнгөтэй) | 3-23 |

**Үргэлжлэл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн № 21-д*

| № | Хувцас хэрэглэлийн нэр | Загварын дугаар |
|---|---|---|
| 16 | Оймс (ноосон болон даавуу) | 3-10<br>3-11 |
| 17 | Ноосон цамц | 3-24 |
| 18 | Захгүй богино ханцуйтай саарал цамц | 3-25 |
| 19 | Кимоно (цамц, өмд) | 3-26<br>3-27 |
| 20 | Дотуур өмд, цамц<br>Эрэгтэй, эмэгтэй | 3-12<br>3-13<br>3-14<br>3-15 |
| **Гутал – 4** | | |
| 21 | Хромон ботинк<br>Эрэгтэй, эмэгтэй | 4-03<br>4-04 |
| 22 | өвлийн богино түрийтэй гутал<br>Эрэгтэй, эмэгтэй | 4-09<br>4-10 |
| 23 | Богино түрийтэй гутал<br>эрэгтэй, эмэгтэй | 4-11<br>4-08 |
| **Бүс, тэлээ – 5** | | |
| 24 | Суран бүс (хар өнгөтэй) | 5-01 |
| 25 | Ёслолын бүс | 5-21 |
| 26 | Тэлээ | 5-22 |
| 27 | Цунх | 5-23 |
| **Мордос, хэрэглэл – 6** | | |
| 28 | Зангианы хавчаар | 6-24 |
| 29 | Малгайн тэмдэг | 6-25 |
| 30 | Дамжааны ялгаа | 6-26<br>6-27<br>6-28<br>6-29 |
| 31 | Мөрдөс | 6-30 |
| 32 | Цолны тэмдэг | 6-31<br>6-32<br>6-33 |
| 33 | "С" үсэг | 6-34 |
| 34 | Таних тэмдэг | 6-12 |
| 35 | Ханцуйн билэгдэл тэмдэг | 6-35 |
| 36 | Дүрэмт хувцасны соёмбоны дүрстэй товч (том, жижиг) | 6-14<br>6-15 |
| 37 | Кнопон товч (мөнгөлөг цагаан өнгөтэй) | 6-37 |
| 38 | Саан унжлага | 6-36 |

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

# МАЛГАЙН ЗАГВАР

| ЁСЛОЛ, АЛБАНЫ МАЙХАН МАЛГАЙ | 1-10 |
|---|---|



| ӨДӨР ТУТМЫН МАЙХАН МАЛГАЙ | 1-11 |
|---|---|



| ХЭЭРИЙН ДААВУУН МАЛГАЙ | 1-12 |
|---|---|



| ӨВЛИЙН ЦЕГЕЙК МАЛГАЙ | 1-04 |
|---|---|



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

ЭРЭГТЭЙ
ЁСЛОЛ, АЛБАНЫ КИТЕЛЬ — 2-38



ЭРЭГТЭЙ
ЁСЛОЛ, АЛБАНЫ ӨМД — 2-39



ЭМЭГТЭЙ
ЁСЛОЛ, АЛБАНЫ КИТЕЛЬ — 2-40



ЭМЭГТЭЙ
ЁСЛОЛ, АЛБАНЫ ЮБКА — 2-41



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ<br>ӨДӨР ТУТМЫН ХҮРЭМ | 2-42 |



| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ<br>ЁСЛОЛ, АЛБАНЫ ӨМД | 2-39 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ<br>ӨДӨР ТУТМЫН ХҮРЭМ | 2-43 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ<br>ӨДӨР ТУТМЫН ӨМД | 2-44 |



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ ХЭЭРИЙН ХҮРЭМ | 2-45 |



| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ ХЭЭРИЙН ӨМД | 2-46 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ ХЭЭРИЙН ХҮРЭМ | 2-47 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ ХЭЭРИЙН ӨМД | 2-48 |



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

ЭРЭГТЭЙ ЮҮДЭНТЭЙ ХҮРЭМ — 2-49



ЭМЭГТЭЙ ЮҮДЭНТЭЙ ХҮРЭМ — 2-51



ЭРЭГТЭЙ ДОТОРТОЙ ӨМД — 2-50



ЭМЭГТЭЙ ДОТОРТОЙ ӨМД — 2-52



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ НӨМРӨГ ЦУВ | 2-53 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ НӨМРӨГ ЦУВ | 2-54 |



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт

## ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ
## ГАДУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

НООСОН ОРООЛТ — 2-55



ЭРЭГТЭЙ САВХИН БЭЭЛИЙ — 2-32



ЭМЭГТЭЙ САВХИН БЭЭЛИЙ — 2-33



ЭРЭГТЭЙ ДААВУУН БЭЭЛИЙ — 2-36



ЭМЭГТЭЙ ДААВУУН БЭЭЛИЙ — 2-37



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ДОТУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ<br>УРТ ХАНЦУЙТАЙ ЦАМЦ | 3-19 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ<br>УРТ ХАНЦУЙТАЙ ЦАМЦ | 3-20 |



| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ<br>БОГИНО ХАНЦУЙТАЙ ЦАМЦ | 3-21 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ<br>БОГИНО ХАНЦУЙТАЙ ЦАМЦ | 3-22 |



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

# ДОТУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

ЗАНГИА — 3-23



ОЙМС — 3-10 (ноосон) 3-11 (даавуун)



НООСОН ЦАМЦ — 3-24



ЗАХГҮЙ БОГИНО ХАНЦУЙТАЙ ЦАМЦ — 3-25



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## ДОТУУР ХУВЦАСНЫ ЗАГВАР

КИМОНО ЦАМЦ — 3-26



КИМОНО ӨМД — 3-27



ЭРЭГТЭЙ ДОТУУР ӨМД, ЦАМЦ — 3-12 (цамц) 3-13 (өмд)



ЭМЭГТЭЙ ДОТУУР ӨМД, ЦАМЦ — 3-14 (цамц) 3-15 (өмд)



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

## ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

# ГУТАЛНЫ ЗАГВАР

| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ ХРОМОН БОТИНК | 4-03 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ ХРОМОН БОТИНК | 4-04 |



| | |
|---|---|
| ЭРЭГТЭЙ БОГИНО ТҮРИЙТЭЙ ГУТАЛ | 4-09 (өвлийн)<br>4-11 |



| | |
|---|---|
| ЭМЭГТЭЙ БОГИНО ТҮРИЙТЭЙ ГУТАЛ | 4-10 (өвлийн)<br>4-08 |



*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт*

ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

## БҮС, ТЭЛЭЭНИЙ ЗАГВАР

СУРАН БҮС — 5-01



ЕСЛОЛЫН БҮС — 5-21



ТЭЛЭЭ — 5-22



ЦҮНХ — 5-23



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар зарлигийн хавсралт

## ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СОНСОГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ
## МӨРДӨС, ХЭРЭГЛЭЛИЙН ЗАГВАР

| | |
|---|---|
| ЗАНГИАНЫ ХАВЧААР | 6-24 |



| | |
|---|---|
| МАЛГАЙН ТЭМДЭГ | 6-25 |



| | |
|---|---|
| СОНСОГЧ МӨРДӨС | 6-30 |



| | |
|---|---|
| "С" ҮСЭГ | 6-34 |



| | |
|---|---|
| СОНСОГЧИЙН ЦОЛНЫ ТЭМДЭГ | 6-31, 6-32, 6-33 |



| | |
|---|---|
| ТАНИХ ТЭМДЭГ | 6-12 |



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

**Татлы Адемийг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын боловсрол, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Туркийн хамтарсан дунд сургуулиудыг хариуцсан "УФУК" боловсролын сангийн ерөнхий захирал Татлы Адемийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 99 | Улаанбаатар хот

**Сергей Дашинимаевич Намсараев, Степан Владимирович Кальмыков нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын боловсрол, шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд Сергей Дашинимаевич Намсараев, Бүгд Найрамдах Буриад Улсын Их сургуулийн захирал Степан Владимирович Кальмыков нарыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 122 | Улаанбаатар хот

**Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай**

Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 180 дугаар зарлигаар батлагдсан цэргийн албан хаагчдын дүрэмт хувцасны загварын 1-51, 1-52 гэсэн кодыг 1-120; 1-53 гэсэн кодыг 1-121; 2-11 гэсэн кодыг 2-80 гэж тус тус өөрчилсүгэй.

3. Хилийн цэргийн офицер, ахлагчийн ёслол, албаны хувцас (загварын код 1-12, 23, 33, 24, 34)-ыг хөх саарал өнгөтэй байхаар тогтоосугай.

4. "Цэргийн хувцасны загварыг батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан 156, 178, 183, 186, 191, 263 дугаар загварыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЗАГВАР

1. Савхин гадартай, салдаг дотортой хагас богино дээл / офицер, ахлагчийн эр, загварын код 1-120/



4. Хилийн цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийн өдөр тутмын китель /Загварын код 3-11



2. Савхин гадартай, салдаг дотортой хагас богино дээл / офицер, ахлагчийн эм, загварын код 1-121/



5. Хилийн цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийн өдөр тутмын өмд /загварын код 3-12/



3. Өдөр тутмын хувцасны малгай / зуны, загварын код 2-80/



6. Хилийн цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийн хиймэл үстэй малгай / загварын код 3-13/



7. Хилийн цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийн хиймэл үстэй хүрэм /Загварын код 3-14/



8. Хилчин дээл /загварын код 3-15/



9. Хилийн цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагчийн ажлын гутал /загварын код 3-19/



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 123 | Улаанбаатар хот

**Мөнхбатын Даваажаргалыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Мэргэжлийн сумо бөхийн барилдааны ур чадварыг богино хугацаанд чадамгай эзэмшин, дээд зиндаанд амжилттай барилдаж буй сумо бөхийн тамирчин Мөнхбатын Даваажаргалыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 124 | Улаанбаатар хот

**Үндэсний баялагт ном хандивлах тухай**

Түүхийн хараа хүрэх эрт дээр цагаас бичиг соёл, ном эрдмийг эрхэмлэж, соёл иргэншлийн гэгээн намтарт өвөрмөц дуурьсалаа үлдээсэн Монголчууд үеэс үед ном эрдмийг дээдэлж, "ном дор мөргөмү" хэмээн адис авч, сүслэн залбирч, номын дээгүүр алхахгүй, гишгэхгүй, номыг газар хаяхгүй шүтээний байранд өргөмжлөж, эрхэмлэн уншдаг ариун ёс журамтай ард түмэн болой.

Монголчууд хэмүү, хятан, монгол бичиг үсгээс аваад руни, дөрвөлжин, тод, соёмбо, төвд, манж, ланз, хятад, латин, кирил зэрэг үсгээр, үйс, илэг, зэгс, цаас, навч, даавуун дээр номоо бичиж есөн эрдэнээр чимэглэж зэс, мөнгө, алтан хуудас бүхий номыг урлаж, дотоод, гадаадын олон хэлээр барлаж, дармаллаж, сийлж, зүмбэрлэж, хатгамаллаж үйлдсэн чулуун ном, сударчилсан ном, дэвтэрлэсэн ном, нугалбар номын асар их өвтэй билээ.

Эдүгээ цаг дор ном туурвигчдын бүтээлийг улсын үндэсний баялаг, оюуны хөрөнгө хэмээн үзэж түмэн олонд хүртээмжтэй болгох, номын өв санг арвижуулах, хадгалах баталгааг бэхжүүлэх талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэд, ард иргэдээс гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1.Эрдэм ухаан, авъяас, хөдөлмөрөө шингээж туурвисан оюуны үнэт өв болох ном бүрээсээ улсынхаа үндэсний баялагт буяны сайн санааны хувь нэмэр болгож, Үндэснийхээ номын санд гурав хүртэл номоор эрдмийн өглөг өгч заншихыг номын зохиогч, эмхэтгэгч, эрхлэгч, хэвлэгч нарт; үндэсний мэдээллийн нийтэд нээлттэй хадгаламж-номын санг хөгжүүлэх түүний сан хөмрөгийг арвижуулах, хамгаалахад боломжоороо хөрөнгө оруулж, санхүүгийн туслалцаа үзүүлж байхыг хувийн хэвшлийн болон олон нийтийн байгууллага, ард иргэдэд тус тус уриалсугай.

2.Ном хандивлагчид, сайн санааны туслалцаа үзүүлэгчдийг жил бүр "Номын өглөгч"-өөр өргөмжлөх, тэднийг алдаршуулах "Талархлын ном"-ыг шинээр бүтээж нийтийн хүртээл болгохыг Үндэсний номын санд зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 265958 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 267497
Хэвлэлийн хуудас 3